



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2021 оны 03 сарын 05
5098

2021 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 03

Эрдэнэ

Малын тоо толгойн албан татварын
хэмжээг тогтоох тухай

Сумын малын тоо толгойн албан татварын хэмжээ тогтоох тухай Засаг дарга Ө.Нямбаярын хуралд өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг сонсож хэлэлцээд Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "д", 18.2, 22 дугаар зүйлийн 22.1.10, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 60 дугаар 60.2.8 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Малчин, мал бүхий өрхийн нэг толгой малд ногдуулах албан татварын хэмжээг дор дурьдсанаар тогтоосугай.

Үүнд:

Тэмээ - 0 төгрөг

Адуу - 500 төгрөг

Үхэр - 500 төгрөг

Хонь - 200 төгрөг

Ямаа - 200 төгрөг

2. Малын тоо толгойд ногдуулсан албан татварыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэн, малын тоо толгой албан татварын тухай хуулийн 7.1-д заасан хугацаанд төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

3. Малын тоо толгойн албан татварын тухай хууль, энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, малын тоо толгойн албан татварын орлогыг сумын 2021 оны төсөвт тусган батлуулах, сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэн төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д заасан зориулалтаар зохих журмын дагуу зарцуулах, энэхүү тогтоолыг сумын нийт иргэдэд сурталчлан ажиллахыг сумын Засаг дарга /Ө.Нямбаяр/-т даалгасугай.

4. Энэхүү тогтоолыг Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарын бичгийн дарга /Б.Туяасайхан/-д даалгасугай.

5. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА Г.ЗОЛБААТАР

